



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/354

Арвайхээр сум

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Арвайхээр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 12/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 3 нэгж талбарын газрын анхны үнэ, хэмжээ, байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулах бөгөөд дуудлага худалдааг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсугай.

3. Дуудлага худалдаа явуулах зар мэдээг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг хүлээн авч дуудлага худалдааг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0684

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар  
сарын 31-ны өдрийн 384 дугаар  
захирамжийн хавсралт

АРВАЙХЭЭР СУМЫН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ  
БҮХИЙ ГАЗАРТ ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ,  
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ

№	Төлөвлөж буй газрын байршил	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газар эзэмшүүлэх Зориулалт	Эзэмшүүлэх газрын хэмжээ /м2/	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ (мян.төг)
1.	Арвайхээр 5 дугаар баг үйлдвэрчид 3-325 (хуучин цэвэрлэх байгууламжийн баруун талд)	3018577	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	3584	10035.2
2.	Арвайхээр 5 дугаар баг үйлдвэрчид 3-323 (хуучин цэвэрлэх байгууламжийн баруун талд)	3018578	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	3514	9839.2
3.	Арвайхээр 5 дугаар баг үйлдвэрчид 3-321 (хуучин цэвэрлэх байгууламжийн баруун талд)	3018579	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	4027	11275.6